



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/83

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх “Шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөв хийлгэх зардал” (Сүмбэр сум, бусад)-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ц.Нямгарав (Аймгийн барилга захиалагч орон сууцны корпораци (ОНӨААТҮГ)-ын инженер)

Гишүүдэд:

Я.Пагамаажав (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Батбаяр (Аймгийн ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

А.Идэрпүрэв (Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. Шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөв хийлгэх зардал” (Сүмбэр сум, бусад) -ын гүйцэтгэгчийг сонгох ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Нямгарав)-д, ашиг сонирхолын зөрчил, авилгаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг бологсугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Аймгийн ЗДТГ-ын дарга (М.Отгонбат)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. МӨНХБААТАР

4122010259